

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 4 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

Тэргүүлэгчдийн хуралдааныг 1 удаа хийж, тус хуралдаанаар “Шилэн дансны тухай” хуулийн болон аймгийн Тэргүүлэгчдийн 2018 оны 41/17-01 тоот тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилт, “Гэр хорооллын стандарт батлах тухай” тогтоолын хэрэгжилт /2013 оны 50 дугаар тогтоол, “Спортын өндөр амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагч, уяач холбоодыг урамшуулах, журмын хэрэгжилтийн тухай /2013 оны 95 дугаар/ Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр батлах тухай, Эрчим хүчний хэмнэлтийн дэд хөтөлбөр батлах тухай, Ажлын хэсэг байгуулах тухай, Баянтээг ХК-ний орон нутгийн өмчийн төлөөлөл томилох зэрэг асуудлуудыг хэлэлцэж, 5 тогтоол гаргав.

Аймгийн ГХУСАЗЗөвлөлөөс аймгийн Цагдаагийн газартай хамтран сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой-2019” тэмцээн, ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Өсвөрийн сэргийлэгч-2019” дэвжээ тэмцээн, мөн “Хүрээлэн байгаа орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” дэд зөвлөлөөс “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг тус тус зохион байгуулав. Уг арга хэмжээнүүдэд ГХУСАЗЗ-өөс нийт 942,000 төгрөг зарцуулав.

Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас Төрийн бус байгууллагуудын нэгдсэн холбоотой хамтран Сумдын ИТХурал болон Засаг дарын тамгын газрын төлөөлөлд Нийтийн сонсголын тухай хуулийн мэдээллийг өгөх, сургалт зохион байгуулав. Сургалтанд Удирдлагын академийн доктор Алтанзул, МУИС-ийн докторант Ч.Сосормаа нар оролцож, “Иргэдийн оролцооны эрх зүйн орчин ба хэрэглээ”, “Төлөөллийн байгууллагын хяналтын чиг үүргийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлэх нь”, “Нийтийн сонсголыг зохион байгуулах тухай” сэдвүүдээр хичээл заав.

Аймгийн ИТХ-аас “Чи-Та” төслийн санхүүжилтээр аймгийн Төрийн бус байгууллагуудын нэгдсэн холбоотой хамтран “2018 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлын талаар” Нийтийн сонсголыг 04 дүгээр сарын 18-ны өдөр анх удаа зохион байгууллаа. Уг сонсголд сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, иргэний нийгмийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, тайлбар мэдээлэл өгөх холбогдох албан тушаалтнууд нийт 73 хүн оролцов.

ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас Сант, Баянгол, Төгрөг, Богд, Гучин-ус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв. Чиг үүргийн дагуу ажилтан бүр хариуцсан ажлынхаа чиглэлээр заавар зөвлөгөө өгч, санал солилцлоо.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Улсын төсвийн санхүүжилтээр шинээр баригдах Арвайхээр хотод 50 ортой “Хүүхдийн эмнэлэг”, Залуучуудын усан спортын цогцолбор, Мэргэд сургуулийн 320 хүүхдийн сургууль, аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газрын барилгын угсралт, Арвайхээр суманд гэр хороололд баригдах 10 гаруй км авто замын ажлыг хугацаанд нь эхлүүлээд байна.

Арвайхээр суманд “Тохижилт-ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд 7300 гаруй мод тариалах нүхийг ухах ажлыг төрийн албан хаагчдын оролцуулан ажиллаж, бизнесийн байгууллагууд өөрсдийн нөөц боломжоор мод, зүлэг тариалах бөгөөд хамгийн том талбай нь Солонгос улсын Ханнара мужийн дэмжлэгтэйгээр ногоон байгууламж бүхий иж бүрэн цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

“Атрын 60 жил”-ийн ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар батлуулан, газар тариаланг идэвхтэй өрнүүлж байсан түүхэн замналыг нийтэд сурталчлан мэдээлэх ажлын хүрээнд Хархорин суманд эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, газар тариалан эрхлэлтийг орон нутгаас бодит дэмжлэг үзүүлэн 10 орчим мянган га-д үр тариа, хүнсний ногоо тариалах газар олголтыг нэмж олгон, аж ахуйн нэгжүүдэд үрийн нөөц, шатах, тослох бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцлөөр олгох ажлыг холбогдох удирдлагуудад уламжлан ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн нээлтийг зохион байгуулж, аймгийн удирдлагууд, Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд, өрхийн эрүүл мэндийн 3 төв, шүдний хувийн хэвшлийн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын багш нар, иргэдийн төлөөлөл 100 гаруй хүн оролцлоо. Аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар 2-6 насны 13606, 7-12 насны 13543 хүүхэд бүртгэлтэй байгаа бөгөөд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 6 настай зорилтот бүлгийн 903 хүүхдээс 807 хүүхдийг хамруулахад 80,0 хувь нь, 12 настай зорилтот бүлгийн 663 хүүхдээс 607 хүүхдийн хамруулахад 76.2 хувьд нь шүдний цоорлын тархалт илэрсэн байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын хэсэг “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн хэрэгжилтийг талаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс зэрэг байгууллагуудад хяналт, шалгалтыг удирдамжийн дагуу зохион байгуулж, зөвлөн туслав.

Арвайхээр хотын шинэ суурьшлийн бүсийн амины орон сууцны хорооллын төсөлд хамрагдаж, 150 гаруй өрх хаус барих захиалгаа өгсөн бөгөөд эдгээр өрхийн төлөөлөлтэй аймгийн удирдлагууд уулзан, төслийг эрчимжүүлэх, нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг шуурхай шийдвэрлэн цахилгааны хангамж, бохирын шугамыг шинээр барих ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

Бүгд Найрамдах Энэтхэг улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мохиндер Пратап Сингх аймагт албаны айлчлал хийж, аймгийн Засаг дарга Г.Ганболдоор ахлуулсан албаны бүрэлдэхүүн хүлээн авч уулзаж, хоёр талын хамтын ажиллагааг эхлүүлэх талаар харилцан тохиролцов.

Франц улсын Алльер мужийн албаны бүрэлдэхүүн аймагт ажиллаж, Арвайхээр суманд Алльер мужийн нэрэмжит гудамжийг шинээр тохижуулахаар харилцан тохиролцож, Баян-Өндөр сумын эрүүл мэндийн байгууллагад хамтран ажиллав.

Аймгийн Засаг дарга Г.Ганболд БНХАУ-д “Бүс ба Зам” олон улсын арга хэмжээнд оролцож энэ үеэр БНХАУ-ын Гүжүа мужтай хамтран ажиллах санамж бичиг байгуулан, энэ хүрээнд Арвайхээр хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд “Баянтээг” нүүрсний уурхайд нүүрс баяжуулах, сайжруулсан түлш үйлдвэрлэх үйлдвэрийг шинээр байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж эхэллээ.

“Орон нутгийн хамгаалалтын тухай” хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг, сум нь орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөтэй байх заалтын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, сумдын Засаг дарга нарт үүрэг, чиглэл өгөх зорилготой нэгдсэн семинарыг зохион байгуулж, хууль зүйн зөвлөмж, арга зүй, тус төлөвлөгөөг боловсруулахад анхаарах асуудлаар санал солилцов.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/103 дугаар захирамжаар Орон нутгийн төсвийн байгууллагын нягтлан бодогч нарын мэдлэг, мэргэшлийн түвшинг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журамыг баталж, төсвийн байгууллагын 83 нягтлан бодогчийн бичиг, баримт, хууль эрх зүй, мэргэшлийн ур чадварын түвшинг үнэлж шалгалт хийлээ. Түвшин тогтоох шалгалтаар хангалтгүй үнэлэгдсэн нягтлан бодогч нарыг мэргэжил дээшлүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх сургалтад хамруулах бөгөөд баримт бичгийн шалгалтад тэнцээгүй нягтлан бодогчдын ажлын байрыг нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалт хийх ажлыг тухайн сумын ЗДТГазар болон шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан зохион байгуулна.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлж буй албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулахад анхаарч ажиллаж, иргэдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн албан хаагчдыг үе шаттайгаар сургалтанд хамруулав. Энэ хүрээнд Монголын Хуульчдын Холбооны гишүүн хуульч, лектор Ц.Азбаярыг урьж “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн аймаг дахь салбарын үйлчилгээний албан хаагчид, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Татварын хэлтэс, Арвайхээр “Тохижилт үйлчилгээ” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Биеийн тамир, спортын газрын 60 гаруй албан хаагчдыг ёс зүй, харилцааны сургалтанд хамруулав.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2019” сарын аянг “Аюулгүй ажиллагаа-Амьдралын баталгаа” уриатайгаар хэрэгжүүлж, нээлтийн арга хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн 71 аж ахуйн нэгж, байгууллага, 300 орчим ажилтан албан хаагч, иргэд оролцлоо. Энэ үеэр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн даатгалын хэлтсээс хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг үзүүлж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, “Орда” хүнсний үйлдвэр, “Ноос Ирээдүй” ХХК-иуд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хэрэгжүүлж буй сайн туршлагаасаа хуваалцлаа.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ

Өвөрхангай аймгийн улс болон орон нутгийн төсвийн 43 байгууллагын төсвийн хэрэгжилт, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг ханган төлбөр тооцоог гүйцэтгэж 4-р сард 5019 ширхэг төлбөрийн хүсэлтээр 27178894933,2 төгрөгийн гүйлгээг хийсэн байна. Санхүү, төрийн сангийн хэлтэстэй холбоотой нийт 29 бичиг ирсэн ба үүнээс хугацаатай бичиг 6, үүнээс 1 бичгийн хугацаа болоогүй байна.

2019 оны 4 дүгээр сарын байдлаар 5 хуулийн этгээд нэмж бүртгэж, 1299 хуулийн этгээд, 129 салбар газар, 604 төрийн бус болон төсөвт байгууллага, 28189 иргэний бүртгэлтэй нийт 30218 бүртгэлтэй татвар төлөгчийн бааз суурьтай үйл ажиллагаа явуулж байна.

НӨАТ 256, онцгой албан татвар 2, бусад 1201 татвар төлөгчийн сар, улирал, жилийн тайланг хүлээн авч, холбогдох программууд дээр татварын ногдол,

тайлангийн уялдаа, тайлангийн хөрвөлт, бусад ногдол программд хөрвөж буй байдалд хяналт тавьж ажиллав

Аймаг, орон нутгийн төсөвт 2019 оны 04 дүгээр сарын байдлаар 3507,4 сая төгрөг төвлөрүүлэхээс 3652,6 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 104,1 хувиар биелүүллээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын 1000,0 мянган төгрөг хожсон 1 иргэний материал хүлээн авч ТЕГ-т хүргүүлэв. ЖДҮ эрхлэгч 1 иргэнд гэрчилгээ олгон ажилласан. Татварын удирдлагын нэгдсэн систем хэрэгжиж "нэхэмжлэхэд суурилсан төлбөрийн даалгавар"-ын дагуу 78 нэхэмжлэхийн код олгосон. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд 7 хоногоор ээлжлэн байцаагч нар иргэдэд үйлчилгээ үзүүлэн, нийт 201 иргэнд үйлчиллээ.

АТӨЯХ-н албан татвар хураах техникийн хяналтын үзлэг Есөнзүйл, Өлзийт, Сант, Баянгол, Гучин-Ус сумдуудад явагдаж, аймгийн хэмжээнд 87,4 сая төгрөгийн албан татвар, 5,6 сая төгрөгийн агаарын бохирдолын албан татвар, замын санд 27,7 сая төгрөгийн, Улаанбаатар дугаартай боловч эзэмшигч нь орон нутгийн харьяалалтай 42 иргэний татварыг аймгийн татварт төвлөрүүллээ. ТЕГ-ын даргын Н/40 дугаар тушаалаар баталсан 2019 оны эхний хагас жилийн татварын хяналт шалгалтад хамруулах эрсдэл бүхий татвар төлөгчийн жагсаалтын дагуу 2019 оны 4 дүгээр сард хийх графикийг хэлтсийн даргаар батлууллаа. 3 сард хяналт шалгалт хийсэн 4 аанб-д программд хянаж баталгаажуулсан. 7 аанб-ын НӨАТ-ын баталгаажуулалтыг хийсэн ба 231.1 сая төгрөгийн зөрчилд 15,9 сая төгрөгийн нөхөн татвар, торгуулийн алдангийн акт шийдвэр гарсан. Татварын хяналт шалгалтын өртэй 2 аанб-ыг шүүхэд өгөх нэхэмжлэл бичсэн.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

Цагдаагийн газартай хамтарсан удирдамжийн дагуу Төгрөг, Богд, Гучин-Ус, Баруунбаян-Улаан сумд, Албаны даргын баталсан удирдамжийн дагуу Хайрхандулаан, Нарийнтээл, Тарагт, Уянга, Сант сумдын Сум хөгжүүлэх сангийн 2017, 2018 оны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж нийт 533076,0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 274219,8 мянган төгрөгийг төлүүлэх улсын ахлах байцаагчийн акт, 159406,9 мянган төгрөгийг төлүүлэх, илэрсэн зөрчлийн арилгуулах улсын байцаагчийн 14 заалт бүхий албан шаардлага өгч ажиллаа.

Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 29/07 тоот удирдамжийн дагуу Сант сумын Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийтдээ 7012,7 мянган төгрөгийн зөрчилд илэрсэн зөрчлийг арилгуулахаар 19 заалт бүхий зөвлөмж өгч, ЕБСургууль хоолны зардлаас илүү зарцуулсан 1458,5 мянган төгрөгийг төлүүлэхээр улсын ахлах байцаагчийн акт тогтоон, 4 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүллээ.

Байгууллагын хүний нөөцийн 2018 оны 4 дүгээр сарын 10-ны байдлаар судалгаа, албаны даргын тушаалаар 2019 оны а/04 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулж, албан тушаалын тодорхойлолтыг гаргаж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хянуулахаар хүргүүлэв.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын нийт 103 ажилтанд, иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид нийт 91 лавлагаа мэдээллийг өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 266, боловсон хүчний 16, захирамжийн төсөлд шийдвэр гаргах зөвшөөрлийн хуудсаар үйлчилгээ үзүүлж, баталгаажигдсан шийдвэрийг бүртгэлжүүлэн санд байршууллаа. Аймгийн Засаг даргаас 04 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 282 шийдвэр батлагдан гарсан бөгөөд тус шийдвэрүүдийг аймгийн www.uvurkhangai.mn цахим сайтад байршуулан иргэдэд мэдээллийг шуурхай авах боломжийг ханган ажиллаж байна.

Хүний эрхийн үндэсний комисстой хамтран “Жендэр ба хүний эрх” сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн төрийн захиргааны байгууллагын удирдлагууд болон эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүд нийт 60 гаруй албан хаагч оролцсон бөгөөд сургалтаар төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудад жендэрийн мэдрэмжтэйгээр шийдвэр гаргах, бодлого боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх, төрийн байгууллага дотор жендэрийн тэгш байдлыг бий болгоход төрийн албан хаагчдын хүлээх үүрэг, хариуцлагыг таниулах зэрэг жендэрийн нэгдсэн ойлголтыг өгсөн юм.

“Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөрийн хүрээнд “Сэтгэлийн хөгжил” ТББ-ын тэргүүн, АА нийгэмлэгийн тэргүүн А.Батсайхантай хамтран аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад “Архины хор хөнөөл” сэдвээр сургалт, лекцийг зохион байгууллаа. Уг сургалт, лекцэд 27 албан хаагч хамрагдлаа.

Аймгийн архивын тасагт байгууллага, иргэдээс 406 өргөдөл хүлээн авч 169 лавлагаа, 658 хуулбар, 75 тодорхойлолт олгоод байна.

“Архивын тоо бүртгэл, эрэл хайлтын программ”-д 198 хадгаламжийн нэгжийн 21522 хуудас, 13855 заалт, 111865 хүний нэр, 19418 байгууллагын нэр 23322 газар зүйн нэр бүхий захирамжлалын баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.

Мөн 173 хадгаламжийн нэгжийн 23204 хуудас баримтыг PDF файл үүсгэн цахим холболтыг хийн, 163 хадгаламжийн нэгжийн 13108 хуудас баримтыг скайнердаж, 235 хадгаламжийн нэгжийн 21002 хуудас баримтыг Photoshop программд оруулсан байна.

Хөмрөг үүсгэгч байгууллагуудын архивын баримтын бүрэлдэхүүн, тоо бүртгэлийн мэдээг нэгтгэн программд шивж, Архивын ерөнхий газарт хүргүүлэв.

ЦАГДААГИЙН ГАЗАР

Цагдаагийн газарт оны эхний 4 сард 1512 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь 628 буюу +71.0 хувиар өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй 353, зөрчлийн шинжтэй 1156 гомдол мэдээлэл бүртгэгдэн шалгаж байна.

Нийт бүртгэгдсэн Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 293 буюу 83,0 хувийг 5 хоногт, 46 буюу 13,0 хувийг 6-аас дээш хоногт, зөрчлийн шинжтэй гомдлын 923 буюу 79.8 хувийг 3 хоногт, 171 буюу 14.8 хувийг 4-өөс дээш хоногт шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 76 нь буюу 5.0 хувийг шийдвэрлээгүй буюу хуулийн хугацаанд шалгаж байна.

Аймгийн хэмжээнд эхний 04 сард 127 холбогдогчтой, 807.2 сая төгрөгийн хохиролтой, 251 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 75 хэргээр буюу +42.6 хувиар өссөн, хэргийн илрүүлэлт 19.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс -11.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хэргийн төрлөөр нь авч үзвэл хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг 12 бүртгэгдэж, 7 буюу 2.4 дахин, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 27 бүртгэгдэж 23-аар буюу +6.7 дахин, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 10 бүртгэгдэж 6-аар буюу +2.5 дахин, - Залилах гэмт хэрэг 14 бүртгэгдэж 12-оор +7.0 дахин, тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 6 бүртгэгдэж 6-аар буюу +6.0

дахин, мал хулгайлах гэмт хэрэг 28 бүртгэгдэж 22 буюу 4.6 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 3 бүртгэгдэж, 2-оор буюу +3.0 дахин, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 16 бүртгэгдэж 15-аар буюу +16.0 дахин тус тус өссөн байна.

Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг, Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, бүртгэгдсэн гэмт хэргийн дотор 68.9 хувийн эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг 118 гэмт хэрэг бүртгэгдснээс иргэдийн өмчийг хулгайлах төрлийн 57, малын хулгайлах гэмт хэрэг 28, тээврийн хэрэгсэл хулгайлах 6, дээрэмдэх 3, залилах 14 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 49 буюу +71.0 хувиар өссөн байна.

Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргийн дийлэнх хувийг цонх хагалах, хөших, цонхоор орох, гэр, орон сууцны хаалга, цоожийг нь эвдэж орох, гэриний тооноор орох, малын хулгайн гэмт хэрэг нь иргэдийн хараа хяналт сонор, сэрэмж сул, малаа байнга хариулага маллагаагүй орхидог, цахимаар иргэдийг хууран мэхэлж, итгэл эвдэх байдлыг ашиглан үйлдэгдэж байна.

Нийт бүртгэгдсэн 251 гэмт хэргээс 68 буюу 27.1 хувийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна.

Зөрчил өмнөх оноос 3443 буюу +48.2 хувиар өссөн байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажын үр дүн, олон нийтийн эргүүл, байнгын пост, цагийн менежменттэй постуудыг ажиллуулснаар тодорхой үр дүнд хүрч байгаагаар тодорхойлогдож байна.

Нийт бүртгэгдсэн 10579 зөрчлөөс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 675 зөрчил байгаа нь өмнөх оны мөн үеэс 58-аар буюу 9.4 хувиар өссөн байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР

“Эх хүүхдийн эрүүл мэндэд бидний оролцоо” салбар дундын зөвлөгөөнийг зохион байгуулж эх хүүхдийн өвчлөл эндэгдэлд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, цаашид анхааран ажиллах асуудлуудыг хэлэлцүүлээ.

Засгийн Газрын 2019 оны 255-р тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг ӨЭМТ, СӨББ, хувийн хэвшлийн шүдний эмнэлэг, эцэг эх хүүхдүүдийн төлөөллийг оролцуулан зохион байгууллаа. Мөн хөтөлбөрт хамрагдах 2-12 насны 27000 гаруй хүүхдийн судалгааг нэрсээр гарган ЭМЯ болон ЭМДЕГ-т хүргэлээ.

“Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж” сургалтыг БОЭТ-ийн сургагч багш нартай хамтран сумын эрүүл мэндийн төвүүдийн эмч, сувилагч 40 хүнийг хамруулан сургалт зохион байгуулсан.

“Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эмч нарын багтай хамтран Тарагт, Уянга, Хужирт сумдад гэмтэл согогийг эрт илрүүлэх үзлэгт 405 иргэнийг хамруулан, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан.

Зүүнбаян-Улаан, Хужирт, Бат-Өлзий, Хархорин сумдад сүрьеэгийн илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эрсдэлт бүлгийн 1453 хүнийг хамруулсан. Сэжигтэй тохиолдол илрээгүй. Бат-өлзий сумын эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/52-р тушаалаар батлагдсан “Сум тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалт”, сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тус тус үнэлгээ хийсэн.

Эрүүл мэндийн газрын болон аймгийн нийт зар мэдээний 8 сайтад шинээр нэвтрүүлж байгаа 2 төрлийн вакцин, өсвөр үеийн эрүүл мэндийн тэмдэгдлэл өдөр, тэдний эрүүл мэнд, давсны зөв зохистой хэрэглээ, тамхины хяналт, хор хөнөөлийн талаар, урьдчилан сэргийлэх үзлэг, дэлхийн эрүүл мэндийн өдөр, нийгмийн эрүүл

мэндэд сувилагч бидний оролцоо, харшлаас сэргийлэх зэрэг эрүүл зан үйл төлөвшүүлэх агуулга бүхий 146 гаруй сэдвийн хүрээнд мэдээлэл сурталчилгааг хүргэсэн нийт 11000 гаруй /давхардсан тоогоор/ иргэдэд хүрсэн байна.

БОЛОВСРОЛЫН САЛБАР

Монголын багш нарын VII их хуралд 23 багш оролцов.

Монгол хэл бичгийн шалгалтыг зохион байгуулж, 82 шалгуулагч орохоор бүртгүүлснээс 78 шалгуулагч хамрагдсан байна.

Элсэлтийн ерөнхий шалгалтыг шууд засалтын технологи ашиглан засахтай холбогдуулан Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтнүүд, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, 12 дугаар ангийн багш нарт сургалт зохион байгуулж, 34 хүн хамрагдлаа.

"Дотуур байр-Хүүхдийн хөгжлийн орчин" аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулж, сумын Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга нар, Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд, нийгмийн ажилтнууд, дотуур байрны багш нар оролцлоо. Зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмжийг нэгтгэн боловсруулж сумдын Засаг дарга нарт болон ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлэв.

Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг 15 төрлөөр зохион байгууллаа.

Соёлын төвийн эрхлэгч нарын "Ур чадварын уралдаан"-ыг зохион байгуулав.

Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн номын санчдын "Ур чадварын уралдаан"-ыг зохион байгуулж, "Нийгэмд номын сангийн үүрэг оролцоо, үр нөлөөг нэмэгдүүлэхэд хүний нөөцийн менежмент чухал болох нь" сэдвээр илтгэл тавьж, харилцан туршлага солилцов.

Соёлын өвийн Улсын тооллогыг Эрдэнэзуу музей, аймгийн музей, сумын Соёлын төвийн орон нутаг судлах танхим, Шанхын баруун хүрээ хийд, Түвхөн хийд зэрэг байгууллага, сүм хийдэд бүрэн хийв.

БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонт, спортын мастер Т.Мэргэн багшийн нэрэмжит 2019 оны Монгол улсын аварга шалгаруулах ширээний теннисний насанд хүрэгчдийн тэмцээнийг аймгийн Ширээний теннисний холбоотой хамтран зохион байгууллаа. Тэмцээнд 20 байгууллагын 23 багийн 181 тамирчин оролцлоо.

Спортын мастер П.Дуламдорж агсны нэрэмжит 2019 оны Хүндийн өргөлтийн насанд хүрэгчдийн Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Тус тэмцээнд хот, хөдөөгийн 16 байгууллагын 105 тамирчин оролцлоо.

Монгол улсын Дархан мэргэн Л.Бадарч агсны нэрэмжит Үндэсний шагайн харваан насанд хүрэгчдид, ахмадын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 19 байгууллагын 240 харваач оролцлоо.

"Хангай жүдо" дэвжээний 1 жилийн хүрээнд зохион байгуулагдсан хангай бүсийн аварга шалгаруулах тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 5 аймгийн 200 тамичрин оролцож Хангай жүдо бөхийн клуб 17 алт 14 мөнгө 21 хүрэл медаль хүртэж багийн дүнгээрээ тэргүүн байрт шалгарлаа

Софт волейболын Арвайхээр сумын аварга шалгаруулах тэмцээнийг 04 дүгээр сарын 12-нд 3 насны ангиллаар зохион байгууллаа. Тус тэмцээнд 9 багийн 114 хүн хамрагдлаа.

Монголын хүүхдийн спортын VI их наадмын анхан шатны 15 хүртлэх насны волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Арвайхээр суманд зохион байгуулж, хөвгүүдийн 12, охидын 24 багийн 294 тамирчин хамрагдлаа. Тэмцээнээс

шилдэг тамирчдыг шалгаруулан “Монголын хүүхдийн спортын их наадам”-ын хангай бүсийн тэмцээнд оролцох эрх олгов.

Монголын хүүхдийн спортын VI их наадмын анхан шатны хөнгөн атлетикийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Арвайхээр суманд зохион байгууллаа. Тус тэмцээнд 10 багийн 176 тамирчин оролцлоо.

CLASSIK Пауэрлифтингийн улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж 21 аймаг, 9 дүүргийн фитнес клубүүдын 500 тамирчин оролцож дүнгээ гаргалаа. Тус тэмцээнд манай аймгийн Д.Мөнхсүлд дасгалжуулагчтай 7 тамирчин өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, мастер ангилалд амжилттай оролцож 5 алт, 5 мөнгө, 3 хүрэл, нийт 13 медаль хүртэж өсвөрийн 57кг жинд оролцсон Х.Цолмонгоо “Спортын дэд мастер”-ын болзол хангалаа.

Бадминтоны өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн Хэнтийн аймгийн Чингис хотод зохион байгуулагдаж 14 багийн 318 тамирчин оролцлоо. Тус тэмцээнд манай аймгийн В.Дониддэмбэрэл дасгалжуулагчтай 18 тамирчин оролцож 15-16 насны охидын ганцаарчилсан төрөлд Б.Хишигтогтох шигшээ 8-д, хосын төрөлд Б.Хишигтогтох, Б.Ганчимэг нар шигшээ 8-д, 17-18 насны охидын ганцаарчилсан төрөлд Г.Алтансүвд шигшээ 8-д, хосын төрөлд Г.Алтансүвд, Б.Должинсүрэн нар шигшээ 8-д шалгарлаа.

Чөлөөт бөхийн өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээн Хэнтий аймгийн Чингис хотод боллоо. Тэмцээнд хот, хөдөөгийн 39 байгууллагын 493 тамирчин өрсөлдснөөс Э.Баттүшиг дасгалжуулагчтай баг тамирчид 1 алт, 1 мөнгө, 3 хүрэл медаль хүртлээ.

“Спортын өндөр амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагчид, уяачдад мөнгөн урамшуулал олгох журам”-ыг шинэчлэн аймгийн ИТХТэргүүлэгчдийн хурлаар батлууллаа.

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

2019 оны 4 дүгээр сарын 25-ны байдлаар аймгийн хэмжээнд 274 ажлын байр бий болсон. Тухайн сард аймгийн хэмжээнд 176 ажил хайгч иргэний бүртгэлийг хөтөлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэснээр ажил хайгч иргэдийн бүртгэл 1944 болж, өмнөх сарын ажил хайгчаас 149 хүнээр өссөн дүнтэй байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд 204 иргэнийг, бүлгийн зөвлөгөө мэдээлэлд 174 иргэнийг хамруулж, хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системд бүртгэлээ.

Ажил хайгчаар бүртгүүлсэн болон мэдээллээ шинэчилсэн 200 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлээ.

Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагаас 200 ажлын байрны захиалга хүлээн авч 174 иргэнийг ажлын байранд зуучиллаа.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2019” сарын аяны хүрээнд “Эрүүл, аюулгүй ажлын байр” дэвтрийг аймгийн 35 хэлтэс, агентлагт, туг, цүнхийг дулаан үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 6 байгууллагад тус тус аялууллаа.

Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 9, Арвайхээр сумын төсвийн байгууллагуудын 36 ажилтан албан хаагчдад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох эрх зүйн актуудын сургалтыг зохион байгуулж, гарын авлага бэлтгэн тараалаа.

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд мэргэжил олгох сургалтыг Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран "Хоол үйлдвэрлэл, тогооч"-ийн мэргэжлээр 20 иргэнийг хамрууллаа.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн гарааны бизнесийг дэмжих "Старт апп" арга хэмжээнд 15-34 насны залуусын бизнес санааны сонгон шалгаруулалтыг зарлаж 41 бүлгийн 94 иргэнийг бүртгэн төслийг хүлээн аваад байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөр ажил олгогчийг урамшуулах арга хэмжээнд хамрагдахаар 2018 онд гэрээ байгуулж, шаардлага хангасан 2 аж ахуйн нэгжийн тус бүр нэг иргэн дээр 5.9 сая төгрөгийн ажил олгогчийн дэмжлэгийг олголоо. Мөн 2 хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил олоход хүндрэлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангасан 1 байгууллагын 1 иргэнд ажил олгогчийг урамшуулах гэрээ байгуулж ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдэд "Дэлгэрэх бүтээмж" ТББ-тай хамтран аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж, 180 иргэнийг хамруулж, төсөл хөтөлбөрийн чиглэлээр мэдээлэл өгч ажиллаж байна.

Ажил олоход хүндрэлтэй хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг байнгын ажлын байраар хангаж байгаа 2 ажил олгогчтой "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчийн урамшууллын гэрээг байгууллаа.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд 19 сумаас 33 төслийг хүлээн авч, Арвайхээр суманд тохижилт ногоон байгууламжийн ажилд хөдөлмөрийн насны ажилгүй 20 иргэнийг хамруулж, түр ажлын байраар хангаж ажиллалаа.

Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээний хүрээнд үрийн ногоо нийлүүлэх тендерийг зарлаж бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй 12 сумын 31 бүлийн 124 иргэнийг бүртгэж ажиллалаа.

Цахим эрхийн бичгийн үйлчилгээнд 945 өрхийн 4926 иргэнд нийт 120704.0 мянган төгрөгийн эрхийн бичгийг олгосон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2 удаагийн хуралдаан зохион байгууллаа. Хурлаар нийт 15 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, 14 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 9 хүүхдэд байнгын асаргаа шинээр тогтоосон. Хурлаар хэлэлцсэн хүүхдүүдээс 5 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа болно.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Гэр бүлийн туршилтын хөтөлбөрийн хүрээнд гэрээр айлчлагч нартай уулзалт зохион байгуулж цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон гэр бүлийн туршилтын хөтөлбөрийн хүрээнд сонгогдсон өрхтэй хэрхэн ажиллах нөөц боломжоо тодорхойлж сар бүрийн эхний 7 хоногийн 5 дахь өдөр эргэн дүгнэх уулзалтыг зохион байгуулж тайлан авч цаашид ажиллах чиглэлээ тодорхойлон ажиллаж байна.

Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын "Гэр бүлийн зөвлөл"-ийн ахлагч нарт арга зүй, үйл ажиллагааны чиглэл өгөх сургалт зохион байгууллаа. Арвайхээр сумын хэмжээнд албан байгууллага, аж ахуй нэгжийн дэргэд нийт 66 "Гэр бүлийн зөвлөл" ажиллаж байна.

Шүүхийн журмаар гэр бүл цуцлахад хүүхдийн асран хамгаалагч тогтоох дүгнэлтээр Баруунбаян-Улаан суманд 1 гэр бүл шинжээчээр ажиллаж 2 иргэн, 2

хүүхэдтэй ганцаарчилсан ярилцлага хийн, сэтгэл зүйн оношилгоо хийж боловсруулан дүгнэлт гаргасан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөөгөөр 10 хүүхэд, 5 иргэн, нийт 14 үйлчлүүлэгч хандлаа. /гэр бүл цуцлалттай холбоотой иргэн - 1, хүүхэд - 2, хүүхэд хүмүүлэх арга иргэн - 2, хууль эрхзүйн зөвлөгөө - 1, гэр бүлийн харилцааны зөрчлөөр - 1, хүүхэд - 4, зан үйлийн өөрчлөлтөөр хүүхэд - 1, харилцааны зөрчил – 5 тус тус байсан/

Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 6-12 ангийн бүх сурагчдаас зан үйлийн тулгамдсан асуудлууд судалгааг 5 үзүүлэлтээр /сэтгэл зүйн хямрал, зан үйл хурцатдал, хэт хөдөлгөөнтөх, харилцаа, үе тэнгийн дарамт/ 702 хүүхдээс судалгааг авч, эрсдэл өндөр 93, эрсдэл дунд 133, хэвийн 476 сурагч байна гэсэн дүгнэлт хийлээ. Тус “Хишиг сургууль” дээр ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллаж сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх эрсдэл өндөртэй 93 хүүхдийн нарийвчилсан судалгааг гаргаж 9 дүгээр ангийн 9 сурагчтай сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Спорт бүжгийн аймгийн аварга шалгаруулах, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд зохион байгуулагчаар оролцож үйл ажиллагааны тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлээ.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд орон нутагтай холбоотой 1 дуудлага мэдээлэл ирж, харъяалах сумын хамтарсан багтай хамтран кейс нээж, нөхцөл байдлын үнэлгээ дүгнэлтийг хийж, шийдвэрлэн ажиллаж байна.

Хүүхдийн тусламжийн 108 утас болон тус газарт биечлэн болон бичгээр ирүүлж буй өргөдөл гомдлын дагуу байгууллагын дарга болон холбогдох асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс бүрдсэн баг 14 хоног тутам кейс хурлыг хийж, тухайн кейс мэдээлэл дээр ажиллаж буй нөхцөл байдлын талаар ярилцаж, санал солилцож, цаашид авах арга зүйн чиглэлээ тодорхойллоо.

Арвайхээр сумын 13 багийн зорилтот бүлгийн 20 өрхийн 40 гаруй хүүхдийг өөрсдийн сонирхсон чиглэлээр нь Хүүхдийн ордны дэргэд хичээллэж буй дугуйлангуудад хамруулж байна.

Залуучуудын хөгжлийн төвийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөны 1.19.1. /Цахим хаягаар дамжуулан салбарын хууль тогтоомж, төрийн үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгөх/ ажлын хүрээнд: Залуучуудын хөгжлийн төвийн Social төлөвлөгөөний дагуу мэдээг оруулж байна. Үүнд: Цаг агаар – 4, Шинэ долоо хоногийн мэнд – 4, Түүхэн мэдээлэл – 1, Сарын онцлох мэдээлэл – 5.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 12.3.3. дахь заалтыг үндэслэн Хүүхэд залуучуудын дунд “Торгоны зам-Өвөрхангай” уран илтгэлийн тэмцээн болон гэрэл зургийн үзэсгэлэнг 2019 оны 04-р сарын 06-ны өдөр зохион байгууллаа. Уран илтгэлийн тэмцээнд хүүхдийн төрөлд 30, өсвөр үе, залуучуудын төрөлд 3, гэрэл зургийн үзэсгэлэнд 7 гэрэл зурагчны 30 гаруй бүтээл оролцлоо.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 12.3.2. дахь заалтын хүрээнд “Гэгээн хангай” насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг хамтран зохион байгууллаа. Тэмцээнд 230 гаруй өсвөр үе, залуучууд оролцож шилдэгүүд тодорлоо.

Төрийн бус байгууллагатай хамтран Нийгэмдээ гэрэл тусгах, шинийг эрэлхийлэгч 25-40 насны залууст зориулан “Lead Mongolia 2019” сургалт, солилцооны хөтөлбөрийн танилцуулга уулзалт зохион байгууллаа. Уулзалтад 10 залуу хамрагдсан.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагын Өвөрхангай орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Дотуур

байр хүүхдийн хөгжлийн орчин” аймгийн зөвлөгөөнийг хамтран зохион байгууллаа.

Нийгмийн даатгалын хэлтэсийн 39 ажилтан албан хаагчдад “Хувь хүний манлайлал”, 4-р сарын 01-нд Богд сумын ЕБС-ийн 26 багш нарт “Харилцаа ба ёс зүй”, 4-р сарын 02-нд Насан туршийн боловсролын төвийн 17 ажилтан албан хаагчдад “Хүүхдийн эрх хамгаалал”, “Харилцаа ба ёс зүй”, 3-р сарын 26-нд 7-р цэцэрлэгийн 44 эцэг эхчүүдэд “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, 3-р сарын 29-ны өдөр тус цэцэрлэгийн 25 ажилтан албан хаагчдад “Хувь хүний хөгжил”, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 50 ажилтан албан хаагчдад “Инээмсэглэл ба харилцаа хандлага” сэдвүүдээр сургалтуудыг зохион байгууллаа.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ДЭД БҮТЦИЙН САЛБАР ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Малын генетик нөөцийн тухай хууль батлагдсантай холбогдуулан бүс нутгийн түвшинд малын удмын санг хамгаалах, үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мал үржүүлгийн ажилд дэвшилтэт технологийг нэвтрүүлэн малын ашиг шимийг нэмэгдүүлэх, үржлийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд Баянгол сумын Баянгол омгийн 10,000 хонь, Нарийнтээл сумын Тээлийн улаан хэвшлийн 10,000 ямаа, Уянга сумын 5,000 сарлаг үхэрт үзлэг ангилалтын ажил зохион байгуулахаар Хүнс, хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамтай гэрээ байгууллаа.

Мал төллөлт, төл бойжилт, том малын зүй бус хорогдолын мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр сумдаас авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлого зохицуулалтын газар болон Мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлэн ажиллаж байна. 04 дүгээр сарын 25-ны байдлаар нийт хээлтэгч малын 55.4 хувь буюу 1321.1 мянган мал төллөснөөс 24.3 мянган төл мал хорогдож гарсан төлийн 98.5 хувь буюу 1297.1 мянган төл бойжиж байна. Мөн нийт хээлтэгчийн 0.3 хувь нь буюу 7.8 мянган мал хээл хаясан. Цаг агаарын нөхцөл байдлын улмаас аймгийн хэмжээнд нийт малын 0.3 хувь буюу 15.0 мянган том мал хорогдсон дүн мэдээтэй байна.

Орон нутагт өсгөн үржүүлж буй цөм сүргийн малын ашиг шимийг нэмэгдүүлэх удмын санг хамгаалах, цаашид баталгаажсан үүлдэр, омгийн малаар батлуулах зорилгоор Гучин-Ус сумын Монголын хоолойн тэмээ, Нарийнтээл сумын Тээлийн улаан нутгийн шилмэл хэвшлийн ямааны үржлийн ажлын арга зүйг Мал аж ахуйн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн докторуудтай хамтран боловсруулсан. Мөн бусад үүлдэр омгийн малаас ялгарах онцлог шинж, генийг тодорхойлохоор Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнтэй хамтран цусны дээж аван шинжилгээ хийгдэж байна.

Үржилд ашиглаж буй хээлтүүлэгч болон цөм сүргийн малыг дахин давтагдашгүй хувийн дугаараар ялган тэмдэгжүүлж, “Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д оруулах ажлын хүрээнд Баянгол сумын “Баянгол омог”-ын 1000 хонь, Нарийнтээл сумын “Тээлийн улаан” нутгийн шилмэл хэвшлийн 1000 ямааны ээмгийг “Тэргүүн сүрэг” ХХК-тай гэрээ байгуулан худалдан авч тус сумдад хүргүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 400 дүгээр тогтоолоор батлагдсан Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд аймгийнхаа эрчимжсэн мал аж ахуйн өнөөгийн байдалд дүгнэлт хийж цаашдынхаа зорилтыг тодорхойлов. Энэхүү арга хэмжээнд 5 сумын 25 эрчимжсэн аж ахуй эрхлэгч, сонирхсон иргэд оролцлоо.

Төв аймгийн Баянчандмань суманд туршлага судлах аялал зохион байгууллаа. Үүнд: “Баян шувуу” 300.0 мянган өндөглөгчтэй шувууны аж ахуй,

ГМЭБ бордооны үйлдвэр, Сүүн далай хоршооны сүүний цех, Монбелларьд үүлдрийг цэврээр нь үржүүлж буй саалийн механикжсан ферм зэрэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцлаа. Хэлэлцүүлэг болон туршлага судалсан ажлын тайланг ХХААХҮЯаманд хүргүүлэв. ХХААХҮЯамны МХС-аас зээл авсан иргэн аж ахуйн нэгжийн зээлийн үлдэгдлийг тулган гарын үсэг зуруулж, хугацаа хэтэрснийг эргэн төлүүлэхээр боллоо.

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготно устгалын ажлыг улсын төсвийн санхүүжилтээр аймгийн хэмжээнд нийт 30.0 мянган га бэлчээрийн талбайд 60 тн бактержуулсан будаагаар Микробиологийн аргаар тэмцэх ажлыг аймгийн Засаг даргын 2019 оны а/247 дугаар захирамжаар Баян-Өндөр, Бүрд, Өлзийт, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Тарагт, Хархорин зэрэг сумдад эхлүүлээд байна.

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготно тархсан 7 суманд газрын даргын “Үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” зөвлөмж хүргүүлж, арга зүйн заавар зөвлөгөө өглөө.

2019 онд бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэхээр улсын төсвийн 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр инженерийн хийцтэй гүн өрмийн 14 худаг, гүн өрмийн 6 худаг сэргээн засварлахаар “Монтегео” ХХК шалгарч гэрээ байгуулаад байна.

Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсэний түүхт 60 жилийн ойн арга хэмжээний нээлт, тариаланчдын улсын зөвлөгөөнд газар тариалангийн салбар хариуцсан мэргэжилтэн болон газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага иргэдийн төлөөлөл 18 хүн оролцлоо.

Газар тариалангийн үйлдвэрлэлд зориулан Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас тариаланч аж ахуйн нэгж, иргэдэд хөнгөлөлттэйгээр эрдэсийн бордооны дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 2 тариаланчийн 1700 кг бордооны захиалгыг холбогдох газруудад хүргүүлж, арга зүйн заавар зөвлөгөө өгч ажиллав.

Хаврын тариалалтад ажиллах техникийн бэлэн байдлын мэдээ, үрийн нөөцийн мэдээг сумдаас авч нэгтгэн яаманд хүргүүллээ.

Аймгийн хэмжээнд “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн А/215 дугаар захирамжаар байгууллаа. Энэ ажлын хүрээнд Бат-Өлзий суманд зохион байгуулагдсан 400 малчны зөвлөгөөнд оролцож “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” аяны тухай танилцуулга, мэдээлэл болон Зээлийн батлан даалтын сангийн тухай танилцуулга, мэдээлэл хийж, гарын авлага материалыг тараав.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоолоор 2019 оныг “Эх оронч худалдан авалтын жил” болгон зарлаж, тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, дотоодод үйлдвэрлэсэн үндэсний бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэхийг нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд уриалахыг үүрэг болгосон.

Энэхүү арга хэмжээний хүрээнд орон нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжиж “Төрийн худалдан авалтад орон нутгийн үйлдвэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” уулзалт хэлэлцүүлгийг 2019 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр зохион байгууллаа.

Шөвөг яр-100%, галзуу 33%, дуут хавдар 37%, Цусан халдварт 59%, Дхх 27 % -ыг малын эмч нарт тараагдаад байна.

МАЭМэндийн албаны эмч, мэргжилтнүүд болон 17 сумын Мал эмнэлгийн тасгийн эмч, мэргэжилтнүүд "Халдварт өвчний дэгдэлтийн судалгаа" сэдэвт онол практикын сургалтанд хамрагдсан.

Мал эмнэлэг хорио цээрийн хяналтын цэгийн үйл ажиллагаа зохих ажил үүрэг хуваарийн дагуу хэвийн явагдаж байгаа ба 4 сарын байдлаар мал эмнэлэг хорио цээрийн хяналтын цэгийн постоор тээврийн хэрэгсэл 4309, тэмээ 18, адуу 390, үхэр 64, хонь 535, ямаа 3, тэмээний мах 25 тн, адууны мах 19 тн, үхрийн мах 89,4 тн, хонины мах 469,5 тн, ямааны мах 130 тн, түүхий эд тэмээний шир 10 ш, адууны шир 624 ш, үхэрийн шир 1446 ш, хонины нэхий 36604 ш, ямааны арьс 62860 ш, ноос ноолуур 27,5 тн тус тус дамжин өнгөрсөн болно.

Отроор явсан болон шилжилт хөдөлгөөн хийж байгаа айл өрхийн судалгааг гаргахад өөрийн аймгийн бусад сумын нутагт 824 өрхийн 71021 мал, өөр аймаг сумын нутагт 148 өрхийн 121676 мал, Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын хөх дэл, чилэнгийн бус нутагт 17 өрхийн 7419 мал байна.

Зүүнбаян-Улаан суманд гарч байгаа адууны өвчний оношийг тогтоох зорилгоор цусны 13, ийлдсийн 20, баасны 18 дээжийг МЭХ, УМЭАЦТЛ-д хүргүүлээ. Нян судлалын лабораторид давхардсан тоогоор 21 сумын 65 дээжинд шинжилгээ хийхэд Нарийнтээл нохой-1, үхэр-1, ЗБУлаан үхэр-1, үнэг-1, Гучин-Ус үхэр-1, Бүрд хонь-1, ямаа-1, Тарагт үхэр-1 галзуу өвчнөөр, Тарагт ямаа-1 ДХХордлого, ЗБУлаан ямаа-1, Арвайхээр хонь-2, Төгрөг ишиг-1 энтеробактериоз өвчнөөр тус тус өвчилсөн болох нь лабораторийн шинжилгээгээр батлагдсан.

"Монгол Ви Ти Нет" ТББ-аас малчдад зориулсан сургалтыг малын зарим өвчин эмгэг, эмийн зөв зохистой хэрэглээ сэдвийн хүрээнд Баян-Өндөр сумын 94 малчин, Сант сумын 69 малчин, Гучин-Ус сумын 60 малчин Төгрөг сумын 92 малчин тус тус хамрагдаад байна.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Газар эзэмших эрх шилжүүлэх хүсэлт 14, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах хүсэлт 1-г хүлээн авч шийдвэрлэсэн. 16 иргэн, аж ахуйн нэгжтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгож нэгж талбарын хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлэн улсын бүртгэлд бүртгэж газрын мэдээллийн санд орууллаа. Аймгийн Засаг даргын 2019 оны А/167 дугаар захирамжаар 12 өрхийн нэр бүхий 31 иргэний өмчлөх эрхийг шилжүүлсэн, А/166 дугаар захирамжаар 22 иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн газрын хэмжээнд өөрчлөлт оруулан мэдээллийн нэгдсэн санд оруулсан, А/168 дүгээр захирамжаар "Монгол Улсын ирэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчлөх хүсэлт гаргасан 34 иргэнд 1.7 га газрыг тус тус өмчлүүлсэн.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Арвайхээр сумын нутаг дэвсгэрт үйлдвэр үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад Хог хаягдлын тухай хууль болон хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах талаар сургалт зохион байгуулж 2019 оны 04 дүгээр сарын 18-нд Арвайхээр сумын 3, 5, 6 дугаар багийн 32 иргэнд "Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, эргүүлэн ашиглах" сэдэвт илтгэл, мэдээлэл өгч ажилласан.

Аймгийн УЦУОШГ-тай хамтран Баянтээгийн коксжуулсан нүүрс болон түүхий нүүрс шатааж агаарт ялгарах азотын исэл, хүхэрлэг хий, нүүрстөрөгчийн дутуу

ислийн хэмжилтийг хийж 11-100кВт хүчин чадалтай шүүлтүүргүй зууханд галлагаа жигдэрсэн үед хүний үйл ажиллагааны нөлөөлөл /хутгалт хийгдээгүй/ -гүй КОКС шатаахад ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС Азотын ислийн агууламж /NOx/, мг/м³ –нь 8.4 дахин их, Хүхэрлэг хийн агууламж /SO₂/, мг/м³ –нь 28.8 дахин их, Нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж /CO/, мг/м³ –нь 3.1 дахин их байна. 10кВт хүчин чадалтай шүүлтүүргүй зууханд КОКС шатаахад ТҮҮХИЙ НҮҮРСНЭЭС Азотын ислийн агууламж /NOx/, мг/м³ –нь түүхийн нүүрснээс 1.2 дахин бага, Хүхэрлэг хийн агууламж /SO₂/, мг/м³ –нь 15,4 дахин бага, Нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж /CO/, мг/м³ –нь 15,5 дахин бага байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

2019 оны 03 сарын 29-31ны өдрүүдэд “ИТМ-2019” аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэн Улаанбаатар хот Мишээл экспод зохион байгуулагдлаа. Өвөрхангай аймгаас аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 29 компани оролцож, зохион байгуулалт, талбайн тохижилт өвөрмөц содон, шинэлэг байдлаар 21 аймгаас шалгарлаа.

Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн хүрээнд Арвайхээр сумын 13 багийн иргэдэд аймгийн БОАЖГазар, Арвайхээр хотын Захирагчын албатай хамтран “Мод сөөг тарих, мандлын цэцэг, зүлэг тарих” арга зүйн сургалтыг 2019 оны 04 сарын 17-19-ны өдрүүдэд багийн нэгдсэн төвд зохион байгуулав. Тус сургалтанд хашаа орчноо тохижуулах хүсэл сонирхолтой 200 гаруй хүмүүс хамрагдсан.

Уянга, Хайрхандулаан, Нарийнтээл, Баруунбаян-Улаан суманд бичил уурхай эрхлэгч эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчин болоод соёл, гэгээрлийн үйл ажиллагаа зохион байгуулах, хамтын ажиллагааг идэвхижүүлэх, санхүүгийн болон эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, өөрт байгаа боломжоо олж нээхэд нь дэмжлэг үзүүлэх, урам зориг өгөх зорилготой “Сэтгэл татам эмэгтэй” сургалт өдөрлөгийг 2019 оны 04 сарын 17-ны өдөр Арвайхээр хотод аймгийн Бичил уурхай эрхлэгчдийн холбоотой хамтран зохион байгуулж сургалтанд 70 гаруй эмэгтэйчүүд оролцлоо.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019 оны 04 дүгээр сарын 18-ны зохион байгуулсан “Алтны бичил уурхайгаас үүдэлтэй бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн төсөл, “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” болон холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлэгт холбогдох сумдын Засаг дарга, байгаль орчны байцаагч нарын хамт оролцсон.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Байгалиа хамгаалай” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөө, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Тагнуулын хэлтсийн хамтран баталсан удирдамжийн хүрээнд ажлын хэсэг Богд сумын 4 дүгээр багийн нутаг Арцын зүүн гэх газар өнгөт чулуу олборлож буй иргэдийн үйл ажиллагаанд Байгаль орчныг хамгаалах тухай, Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилтэнд хяналт шалгалт явуулсан.

Ажлын хэсэг хууль бусаар ердийн ашигт малтмал болох өнгөт чулуу олборлосон 10 машинтай нэр бүхий 25 иргэний үйл ажиллагааг зогсоож, олборлосон өнгөт чулуу, цахилгаан мотор, молдок, хүрз зэрэг багаж хэрэгслийн хураан авч, байгаль орчны хяналтын улсын байцаагч 15 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авсан.

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Энэ сард агаарын дундаж температур 4.9 – 10.4 градус дулаан , нийт нутгаар ихэнх хугацаанд шөнөдөө -2 градус хүйтэнээс 4градус дулаан, өдөртөө 12-17 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундажтай харьцуулж үзвэл олон жилийн дунджаас 1,0-2,5 градусаар дулаан байлаа. Нийт нутгаар салхи секундэд 5-10м/сек, Сант, Хужирт, Арвайхээр, Бүрд, Гучин-Ус, Баянгол, Өлзийт, Богд, Төгрөг, Баруунбаян-Улаан, Баян-Өндөр сумдын нутгаар 16-21 м/сек хүрч салхилсан байна. Хужирт, Баруунбаян-Улаан, Бат-Өлзий, Зүйл сумдын нутгаар 0,2-1,6мм, Хайрхандулаан, Богд сумдын нутгаар 7.0-9.2 мм тунадас унасан байна.

Бэлчээрийн ургамлын ургалтын байдал: Баян-Өндөр, Баянгол, Зүйл, Уянга сумдын нутгаар ургамал цухуйж эхлээгүй. Бусад сумдын нутгаар ургамал цухуйж эхэлсэн ба ургамлын өндөр 0-1см байна.

Орхон гол: Бат-Өлзий сумын ус судлалын харуул орчим усан зах үүсэж, мөсөн дээгүүр ус урссан, мөсний зузаан 140 см буюу олон жилийн дунджийн орчим, усны түвшин мөсний үзэгдлийн нөлөөгөөр олон жилийн дунджаас 67 см-ээр их, өмнөх өдрөөс 16 см-ээр буурсан, дундаж гүн 89 см, хамгийн их гүн 1 м 45 см байгаа бол Хархорин сумын ус судлалын харуул орчим усны түвшин олон жилийн дунджаас 28 см-ээр бага, дундаж гүн 48 см хамгийн их гүн 1м орчим байна.

Хөгшин Орхон гол: Усны түвшин Хархорин сумын ус судлалын харуул орчим олон жилийн дунджаас 10см-ээр бага, дундаж гүн 19см, хамгийн их гүн 27см орчим байна.

Онги гол: Уянга сумын ус судлалын харуул орчим усан зах үүссэн, мөсний зузаан 40см, усны түвшин олон жилийн дунджаас 14см-ээр бага, дундаж гүн 32см, хамгийн их гүн 57см байна. Арвайхээр сумын ус судлалын харуул орчим усны түвшин олон жилийн дунджийн орчим, дундаж гүн 22см, хамгийн их гүн 55см байна.

Таац гол: Нарийнтээл сумын ус судлалын харуул орчим усны түвшин олон жилийн дунджийн орчим, өмнөх өдрөөс 10см-ээр нэмэгдсэн, дундаж гүн 58см, хамгийн гүн 66см байна.

Зэгстэй гол: Өлзийт сумын ус судлалын харуул орчим усны түвшин олон жилийн дунджаас 20см-ээр бага, өмнөх өдрөөс 9см-ээр буурсан, дундаж гүн 8см, хамгийн их гүн 17см байна.

Орхон, Онги голын эхээр мөсөн дээгүүр ус урссан, усны түвшин буураагүй тул гол гатлах боломжгүй байгааг анхааруулж байна.

Урьдчилан мэдээлэх ажлын хүрээнд

Цаг агаарын нарийвчилсан мэдээ зохиож таарц нь 96.2хувь

Хоногийн урьдчилсан мэдээ зохиож таарц нь 94.4 хувь

Цаг агаарын аюул агаар мэдээний ирц болон чанар 100 хувь

Цаг агаарын хоногийн урьдчилсан мэдээг аймгийн сум бүрээр нарийвчилан зохиож www.tsag.agaar.mn цахим хуудсанд 30 удаа тавьж нийтийн хэрэгцээнд үйлчилсэн.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар орон нутгийн өмчит 192 хуулийн этгээд байгаагаас барилга байгууламжтай буюу үл хөдлөх хөрөнгөтэй үнэлгээнд хамрагдсан 144 хуулийн этгээд, үнэлгээнд хамрагдаагүй 48, сумдын 82 сангийн нийт 274 байгууллагын санхүүгийн болон үл хөдлөх хөрөнгийн тайлан, газрын үнэлгээ бүртгэл, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний тайланг нэгтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүллээ.

Газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ:

Аймгийн хэмжээнд 290 нэгж талбарын 1 753 937.23 м.кв талбай бүхий газар эзэмших, ашиглах эрхийг Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолд заасны дагуу үнэлж 11 123 099 584 төгрөгөөр санхүүгийн тайлан балансын эргэлтийн бус хөрөнгийн биет бус хөрөнгөд тусгууллаа. 290 нэгж талбарын газраас 249 нэгж талбарын газар буюу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж эзэмших эрхээ баталгаажуулсан байна. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд газрыг ихэнх тохиолдолд худалдаа, бүх төрлийн үйлчилгээний зориулалтаар авч ашиглаж байна.

Суманд газрын хэмжилтийг мэргэжлийн тусгай багаж, хэрэгслээр хэмжихэд сүлжээ байхгүйн улмаас багийн төвүүдийн газрыг хэмжих боломжгүй байсан.

Барилга байгууламжийн үнэлгээ:

Барилга: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дансанд бүртгэлтэй 554 ш 109 317 783 799.18 мян.төг-ийн сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төв, албан контор, автомашины граж, багийн төв, дулааны үйлдвэрийн барилгуудыг дахин үнэлж 78 053 756 123.68 мян.төгрөгөөр санхүүгийн тайланд тусгууллаа.

Байгууламж: Барилга, байгууламжийн дансанд бүртгэлтэй дулаан, цэвэр, бохир, цахилгааны шугам, зам, талбай, гүүрийн байгууламж болох 149 ш 7 552 418 149,51 тэрбум төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж 10 163 074 463.57 төгрөгөөр санхүүгийн тайланд тусгууллаа.

Нийтийн эзэмшлийн байгууламж: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тохижилтийн хөрөнгө болох явган зам, хашаа, хайс, сүүдрэвч, ногоон байгууламж, гэрэлтүүлэг зэрэг 467 ширхэг 14 802 431 172.58 төгрөгийн хөрөнгийг аргачлалын дагуу дахин үнэлүүлж 10 648 317 935.46 төгрөгийг байгууллагуудын дансанд тусгууллаа.

Үнэлгээнд хамрагдаагүй хөрөнгө: Барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгө 749 ширхэг 55 974 372 123.64 төгрөг, газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх үнэлгээнд 15 сумын 27 байгууллагын газрын үнэлгээнд хамруулаагүй газрын хэмжээ талбай зөрүүтэй, гэрчилгээгүй, бичиг баримт байхгүй учраас үнэлгээнд хамруулаагүй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба нь тус сард улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах 8, бараа, тоног төхөөрөмж нийлүүлэх 3, нийт 11 тендерийг зарласан.

Мөн Сургуулийн барилга, 320 суудал, /Өвөрхангай, Арвайхээр сум/, Сургуулийн барилга, 320 суудал /Өвөрхангай, Хархорин сум/, Залуучуудын усан спортын цогцолборын барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/, Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/, Дотуур байрын барилга, 100 ор /Өвөрхангай, Уянга сум/ нийт 4 ажлын тендерүүдийг үнэлэж, гүйцэтгэгчийг сонгон шалгарууллаа.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

МХЕГ-ын даргын баталсан 01/82 тоот нэгдсэн удирдамжийн хүрээнд "Аюултай хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх" үйл ажиллагаанд тандалт судалгааг 6 байгууллагад хийлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас баталсан 2019 оны 02 дугаар сарын 02-ны 01/64 тоот удирдамжийн хүрээнд 4 сард Хайрхандулаан сумын Хүлгийн дээд ХХК, Таацын алтан зам ХХК-ийн халаалтын зууханы янданд, Нарийнтээл сумын Өв менежмент ХХК, Баянтээг ХК-ийн халаалтын зуух, Баруунбаян-Улаан сумын

Өвбаян-Улаан ХХК-ийн халаалтын зуухны янданд тандалт судалгааг загвар хүснэгтийн дагуу хийлээ.

Хайрхандулаан, Нарийнтээл, Баруунбаян-Улаан сумдад төлөвлөгөөт шалгалт 3, зөвлөн туслах үйлчилгээ 1 аж ахуйн нэгжид үзүүлж, холбогдох албан тушаалтнуудад заавар зөвлөгөө өгч, илэрсэн дутагдлыг арилгуулахаар хамтарсан албан шаардлага, зөвлөмж хүргүүллээ.

Химийн хорт болон аюултай бодисын чиглэлээр 2 төлөвлөгөөт шалгалт, 4 зөвлөн туслах үйлчилгээ, 3 байгууллагат тандалт судалгаа хийхээр төлөвлөсөн. Шалгалтын явцад илэрсэн дутагдлыг арилгуулахаар 2 албан шаардлага, 4 зөвлөмжийг холбогдох газарт хугацаатай хүргүүлсэн. Хамрагдсан бүх аж ахуйн нэгж, байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулсан.

МХЕГ-ын даргын баталсан 01/40 дугаар удирдамжийн хүрээнд шинээр үйл ажиллагаа эрхэлж буй Хайрхандулаан суманд дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй 1 аж ахуйн нэгж, Нарийнтээл суманд үйл ажиллагаа эхэлсэн мах хадгалах зоорийн үйл ажиллагаатай танилцаж, холбогдох ажилтнуудад заавар зөвлөгөө өгч, илэрсэн дутагдлыг арилгуулахаар нэг албан шаардлага өглөө.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийх төлөвлөгөө батлан тус аймагт үйл ажиллагаа явуулж буй 2 аж ахуйн нэгжид шалгалт хийгдэж байна.

Газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан сумдын 8 худалдааны газарт төлөвлөгөөт шалгалт хийж, 4 газарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. 5 нь бага, 7 нь дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. Эрсдэлийг бууруулахаар 74 заалт бүхий 8 албан шаардлага, 38 заалт бүхий 4 зөвлөмж хүргүүлэн гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна.

Арвайхээр сумын хоол үйлдвэрлэлийн 4 объектод төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэхэд 2 объект бага, 2 объект дунд эрсдэлтэй үнэлэгдлээ. Нийт 31 заалт бүхий 4 зөвлөмж хүргүүлж ажилласан.

Газрын даргын баталсан 15/158 тоот удирдамжийг үндэслэн иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Арвайхээр сумын Арвин худалдааны төвд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулахаар 7 заалт бүхий 15/02/005/130 тоот албан шаардлага хүргүүлж, хууль тогтоомжийг сурталчлан, зөвлөгөө өглөө.

Арвайхээр сумын иргэн Б.Амарцогтын хүсэлт, газрын даргын баталсан 15/154 тоот удирдамжаар Орхон цайны газрын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхэд зөрчил дутагдалын 75 %-ийг арилгаж, ажлын байранд өргөтгөл хийсэн тул 15/02/006/16 тоот актаар сэргээсэн.

Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтаар: 01/78 тоот удирдамжийн хүрээнд 2 иргэний хадгалсан үрийн төмсийг лабораторийн шинжилгээнд хамруулж, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын танилцуулгыг МХЕГазарт хүргүүлсэн.

СУМДЫН МЭДЭЭЛЭЛ

Арвайхээр суманд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр сургуулийн гадна байгаа 6-18 насны хүүхдийг илрүүлэх судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээ шаардлагатай байгаа 53 хүүхдийг илрүүлснээс 9 хүүхдийн эцэг эхийн хүсэлтийг аймгийн "Эрүүл мэндийн магадлангийн комисс"-т хүргүүллээ.

Гучин-Ус суманд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зарласан "Тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх" жилийн нээлтийг үйл ажиллагааг зохион байгуулсан. Энэ үеэр зорилтот жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг

танилцуулж нээлтэд оролцсон иргэдэд гялгар уутны хэрэглээг багасгах зорилгоор Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд 100 ширхэг даавуун тор хийж тараасан.

Хайрхандулаан сумаас газрын харилцаа цахимаар болон танхимаар дуудлага худалдаа зохион байгуулж, цахим дуудлага худалдаанд оролцогч байхгүй учир хүчингүй болсон. Өмчилсөн газраа улсын бүртгэлд бүртгүүлэх, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар хүсэлт гаргасан 1 иргэнд шаардлагатай баримтаар үйлчилж, иргэдийн гаргасан хүсэлтийн дагуу 3 байршилд газар хэмжилт хийлээ.